ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

**АУДИТЫН КОД: ТӨА-2026/151/НА-СТА-ТШЗ**

**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН**

Зуунмод 2026 он


Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор: Б.Адъясүрэн

Утас: 70273204 Цахим хаяг: adiyasurenb@audit.gov.mn

**Гэрээгээр гүйцэтгэсэн:**

Уваа уул аудит ХХК захирал: Ч.Мөнхтуяа


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2026.02.25 № 01/194
танай ____________-ны № ________________-т

ТӨВ АЙМГИЙН ЗААМАР
СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Л.АРИУНТУЯА ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Заамар сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Заамар сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Боловсролын ерөнхий газраас 1,474.0 мянган төгрөг, Эцэг эхээс 2,494.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж хандиваар авсан байна. Сумын Засаг даргын Тамгын газраас Steam тоглоомын 20,000.0 мянган төгрөгийн төслийг батлуулан, “Эс жижи прэнд” ХХК-аас 5 төрлийн 184 ширхэг тоглоомыг хүлээн авсан байна.

**Аудитын гол асуудал**

Тус цэцэрлэгийн “Б” байрны дээврийн засварын ажлыг орон нутгийн төсвийн хөрөнгөөр нийт 79,717.2 мянган төгрөгийн үнэ бүхий цэцэрлэгийн дээврийн засварын ажлыг орлогод авсан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Тус байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилт бүхий нийт 40 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 91.7 хувиар дүгнэсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

4126020244

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ХИШИГЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **283,807,151.35** | **128,117,530.79** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **203,296,362.35** | **57,864,947.79** |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | **203,296,362.35** | **57,864,947.79** |
| **3121** | **Төгрөг** | **203,296,362.35** | **57,864,947.79** |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 203,296,362.35 | 57,864,947.79 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **80,510,789.00** | **70,252,583.00** |
| **354** | **Хангамжийн материал** | **80,510,789.00** | **70,252,583.00** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 150,000.00 | 150,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | - | 37,500.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 149,000.00 | 75,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 8,395,110.00 | 4,724,300.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 71,816,679.00 | 65,265,783.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **735,043,844.72** | **791,128,734.30** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **735,043,844.72** | **791,128,734.30** |
| **392** | **Биет хөрөнгө** | **715,253,844.72** | **771,338,734.30** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 701,726,573.00 | 781,443,787.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (62,944,173.90) | (74,639,616.78) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 67,237,460.00 | 55,090,420.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (39,141,099.91) | (31,710,497.14) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 63,673,350.67 | 60,963,067.87 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (32,942,648.89) | (32,545,293.84) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 54,700,829.00 | 54,440,829.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (38,373,925.25) | (43,065,441.81) |
| 39217 | Ном | 1,317,480.00 | 1,361,480.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | **19,790,000.00** | **19,790,000.00** |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 19,790,000.00 | 19,790,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,018,850,996.07** | **919,246,265.09** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **-** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **-** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,018,850,996.07** | **919,246,265.09** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **1,018,850,996.07** | **919,246,265.09** |
| **511** | **Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан** | **62,132,028.00** | **62,132,028.00** |
| 51102 | - хувийн | 62,132,028.00 | 62,132,028.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | **924,647,144.27** | **825,042,413.29** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 924,647,144.27 | 924,647,144.27 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (99,604,730.98) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 32,071,823.80 | 32,071,823.80 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,018,850,996.07** | **919,246,265.09** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан** **/төгрөгөөр/**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **466,479,600.00** | **1,030,124,214.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **-** | **103,846,014.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | - | 101,351,214.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | - | 81,191,214.00 |
| 120009 | Бусад орлого | - | 100,000.00 |
| **122** | **Тусламжийн орлого** | - | 2,494,800.00 |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | - | 2,494,800.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **38,965,000.00** | **926,278,200.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | - | 858,824,800.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | - | 858,824,800.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 427,514,600.00 | - |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 38,965,000.00 | 67,453,400.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 38,965,000.00 | 67,453,400.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **453,913,991.95** | **1,129,728,944.98** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **453,913,991.95** | **1,129,728,944.98** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 453,913,991.95 | 1,128,289,361.58 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 309,666,552.20 | 784,001,853.57 |
| 210101 | Үндсэн цалин | 221,624,654.83 | 481,715,702.24 |
| 210102 | Нэмэгдэл | 76,163,587.57 | 266,991,084.86 |
| 210104 | Урамшуулал | 11,878,309.80 | 35,295,066.47 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 32,655,235.58 | 98,302,550.99 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 26,424,028.41 | 77,865,988.37 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,642,138.32 | 5,212,460.19 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 966,904.88 | 2,324,573.34 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 591,110.24 | 2,844,339.34 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,031,053.73 | 10,055,189.75 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 34,211,335.73 | 62,432,786.60 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,985,942.73 | 8,698,754.60 |
| 210302 | Түлш, халаалт | 30,225,393.00 | 53,734,032.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 13,773,088.00 | 46,566,796.00 |
| 210401 | Бичиг хэрэг | - | 3,006,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | - | 1,037,600.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | - | 2,060,900.00 |
| 210404 | Ном, хэвлэл | - | 316,600.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | 407,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | - | 8,814,650.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 13,773,088.00 | 30,923,146.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 38,419,422.00 | 91,989,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 38,419,422.00 | 91,989,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,910,000.00 | 2,100,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,910,000.00 | 2,100,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | - | 5,280,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | - | 5,280,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 725,700.00 | 2,772,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 330,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | - | 1,008,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 725,700.00 | 1,434,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 22,552,658.44 | 34,844,374.42 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,048,220.00 | 3,330,250.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,266,800.00 | 1,000,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 13,237,638.44 | 30,514,124.42 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | - | 1,439,583.40 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | - | 1,439,583.40 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **12,565,608.05** | **(99,604,730.98)** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **12,565,608.05** | **(99,604,730.98)** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан** **/төгрөгөөр/**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН** | **466,479,600.00** | **926,378,200.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **-** | **100,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **-** | **100,000.00** |
| 120009 | Бусад орлого | - | 100,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **466,479,600.00** | **926,278,200.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **-** | **858,824,800.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | - | 858,824,800.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 427,514,600.00 | - |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **38,965,000.00** | **67,453,400.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 38,965,000.00 | 67,453,400.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **422,290,833.77** | **1,068,896,614.56** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **422,290,833.77** | **1,068,896,614.56** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **422,290,833.77** | **1,067,457,031.16** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **308,211,652.46** | **784,001,853.57** |
| 210101 | Үндсэн цалин | 220,169,755.09 | 481,632,919.34 |
| 210102 | Нэмэгдэл | 76,163,587.57 | 266,991,084.86 |
| 210104 | Урамшуулал | 11,878,309.80 | 35,377,849.37 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **32,655,235.58** | **98,302,550.99** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 22,604,908.28 | 67,408,545.15 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,648,621.92 | 7,822,717.53 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,304,511.00 | 4,014,643.62 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,213,344.88 | 3,768,360.97 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,883,849.50 | 15,288,283.72 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **34,211,335.73** | **63,029,036.60** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,985,942.73 | 8,698,754.60 |
| 210302 | Түлш, халаалт | 30,225,393.00 | 53,734,032.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | - | 596,250.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **-** | **2,060,900.00** |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | - | 2,060,900.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **35,181,610.00** | **88,318,190.00** |
| 210502 | Хоол, хүнс | 35,181,610.00 | 88,318,190.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **2,000,000.00** | **2,984,780.00** |
| 210604 | Урсгал засвар | 2,000,000.00 | 2,984,780.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **725,700.00** | **1,539,000.00** |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 725,700.00 | 1,539,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **9,305,300.00** | **27,220,720.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,038,500.00 | 18,163,510.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,266,800.00 | 9,057,210.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **-** | **1,439,583.40** |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **-** | **1,439,583.40** |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **44,188,766.23** | **(142,518,414.56)** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **-** | **2,913,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **2,913,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **-** | **2,913,000.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | - | 2,913,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-** | **(2,913,000.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | **44,188,766.23** | **(145,431,414.56)** |

| | | | |
|---|---|---|---|
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **76,960,796.85** | **203,296,362.35** |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **121,149,563.08** | **57,864,947.79** |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан** **/төгрөгөөр/**

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 62,132,028.00 | 32,071,823.80 | 790,655,371.62 | 884,859,223.42 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **62,132,028.00** | **32,071,823.80** | **790,655,371.62** | 884,859,223.42 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | - |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 12,565,608.05 | 12,565,608.05 |
| **2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **62,132,028.00** | **32,071,823.80** | **924,647,144.27** | 1,018,850,996.07 |
| **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **62,132,028.00** | **32,071,823.80** | **924,647,144.27** | 1,018,850,996.07 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **62,132,028.00** | **32,071,823.80** | **924,647,144.27** | 1,018,850,996.07 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | - |
| Тайлант үеийн үр дүн | - | - | (99,604,730.98) | (99,604,730.98) |
| **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **62,132,028.00** | **32,071,823.80** | **825,042,413.29** | 919,246,265.09 |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан** **/төгрөгөөр/**

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **932,575,200.00** | **926,278,200.00** | **6,297,000.00** | **99.3** |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **67,453,400.00** | **67,453,400.00** | **-** | **100.0** |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 67,453,400.00 | 67,453,400.00 | - | 100.0 |
| **1310** | **УЛСЫН ТӨВЛӨРСӨН САНХҮҮЖИЛТ** | **865,121,800.00** | **858,824,800.00** | **6,297,000.00** | **99.3** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 865,121,800.00 | 858,824,800.00 | 6,297,000.00 | 99.3 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,111,459,000.00** | **1,070,370,031.16** | **41,088,968.84** | **96.3** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,111,459,000.00** | **1,070,370,031.16** | **41,088,968.84** | **96.3** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,111,459,000.00** | **1,070,370,031.16** | **41,088,968.84** | **96.3** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **811,957,400.00** | **784,001,853.57** | **27,955,546.43** | **96.6** |
| 210101 | Үндсэн цалин | 521,628,500.00 | 481,632,919.34 | 39,995,580.66 | 92.3 |
| 210102 | Нэмэгдэл | 268,176,900.00 | 266,991,084.86 | 1,185,815.14 | 99.6 |
| 210104 | Урамшуулал | 22,152,000.00 | 35,377,849.37 | (13,225,849.37) | 159.7 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **100,984,600.00** | **98,302,550.99** | **2,682,049.01** | **97.3** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 68,506,200.00 | 67,408,545.15 | 1,097,654.85 | 98.4 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,119,600.00 | 7,822,717.53 | 296,882.47 | 96.3 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,059,800.00 | 4,014,643.62 | 45,156.38 | 98.9 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,059,800.00 | 3,768,360.97 | 291,439.03 | 92.8 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 16,239,200.00 | 15,288,283.72 | 950,916.28 | 94.1 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **64,453,400.00** | **63,029,036.60** | **1,424,363.40** | **97.8** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 10,719,300.00 | 8,698,754.60 | 2,020,545.40 | 81.2 |
| 210302 | Түлш, халаалт | 53,734,100.00 | 53,734,032.00 | 68.00 | 100.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | - | 596,250.00 | (596,250.00) | |
| **2105** | **Нормативт зардал** | **95,455,100.00** | **88,318,190.00** | **7,136,910.00** | **92.5** |
| 210502 | Хоол, хүнс | 95,455,100.00 | 88,318,190.00 | 7,136,910.00 | 92.5 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **3,000,000.00** | **2,984,780.00** | **15,220.00** | **99.5** |
| 210604 | Урсгал засвар | 3,000,000.00 | 2,984,780.00 | 15,220.00 | 99.5 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **4,633,200.00** | **3,307,900.00** | **1,325,300.00** | **71.4** |
| 210806 | Мэдээлэл технологийн үйлчилгээ | 4,633,200 | 3,307,900 | 1,325,300.00 | 71.4 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **30,975,300.00** | **30,425,720.00** | **549,580.00** | **98.2** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 23,047,700 | 22,703,810 | 343,890.00 | 98.5 |
| 210902 | Сургалт, дадлага, бэлтгэлийн зардал | 7,927,600 | 7,721,910 | 205,690.00 | 97.4 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | **203,296,362.35** | | |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | **57,864,947.79** | | |

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

### 5.1 Залруулсан алдаа

Аудитаар нийт 6,426.8 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцооллын 4 алдаа илэрснийг аудитын явцад бүрэн залруулав. Үүнд:

- Үндсэн хөрөнгийн тодруулга тайланд төсвийн хөрөнгөөр авсан 2,248.0 мянган төгрөгийг Мөнгөн гүйлгээний тайланд тусгаагүй байна.
- Санхүүгийн үр дүнгийн тайланд тусгасан Үнэ төлбөргүй хүлээн авсан-Бараа материалын 150.0 мянган төгрөгийг Тодруулга тайланд зөрүүтэй тусгасан байна.
- Санхүүгийн үр дүнгийн тайланд тусгасан Үнэ төлбөргүй хүлээн авсан-үндсэн хөрөнгийн 3,968.8 мянган төгрөгийг Санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй гарсан зардалд 60.0 мянган төгрөг ангилал буруу бүртгэсэн зэрэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна”, 15.2-т “нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Аудитаар илэрсэн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 4,525.8 мянган төгрөгөөс бага байгаа тул **“Өөрчлөлтгүй”** дүгнэлт өглөө.

### 5.2 Залруулаагүй зөрчил

Аудитаар 3 зөвлөмж хүргүүллээ.

#### 5.2.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. ***Санхүүгийн тайлантай холбоотой асуудал***

<u>Илрүүлэлт:</u>

Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалын дагуу Санхүүгийн тайлангийн мэдээлэл агуулсан тодруулга тайлан бэлтгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна", 8.1.5-д "Санхүүгийн тайлангийн тодруулга", Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 8.3-д "Санхүүгийн тайлангийн тодруулга нь Санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланд толилуулаагүй боловч тэдгээрийн аль нэгийг ойлгоход хамааралтай нэмэлт мэдээллээр хангана" гэж заасантай тус тус нийцэхгүй, “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайланг тайлбар тодруулгын хамт бэлтгэж байх зөвлөмж өгөв.

***2.Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал***

<u>Илрүүлэлт:</u>

Байгууллагын үндсэн үйл ажиллагаанд ашиглагдаж буй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 233 ширхэг 46,934.2 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоогоогүй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох” тухай 271 дүгээр тогтоолын 7.1-д “төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ”, Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ” гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна

Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ өртгөө нөхсөн хөрөнгийг чанар байдлыг үнэлэн, ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоож, Төв аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүргүүлж шийдвэрлүүлэн, бүртгэх зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг 2025 оны 6 дугаар сарын 10-ний өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6.АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл** */мянган төгрөгөөр/*

| д/д | Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Үндсэн хөрөнгийн тодруулга тайланд төсвийн хөрөнгөөр авсан 2,248.0 мянган төгрөгийг Мөнгөн гүйлгээний тайланд тусгаагүй байна. | 1 | 2,248.0 | | | 1 | 2,248.0 | 1 | 2,248.0 | | |
| 2 | Санхүүгийн үр дүнгийн тайланд тусгасан Үнэ төлбөргүй хүлээн авсан-Бараа материалын 150.0 мянган төгрөгийг Тодруулга тайланд зөрүүтэй тусгасан байна. | 1 | 150.0 | | | 1 | 150.0 | 1 | 150.0 | | |
| 3 | Санхүүгийн үр дүнгийн тайланд тусгасан Үнэ төлбөргүй хүлээн авсан-үндсэн хөрөнгийн 3,968.8 мянган төгрөгийг Тодруулга тайланд хандиваар тусгасан байна. | 1 | 3,968.8 | | | 1 | 3,968.8 | 1 | 3,968.8 | | |
| 4 | Санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй гарсан зардалд 60.0 мянган төгрөг ангилал буруу бүртгэсэн байна. | 1 | 60.0 | | | 1 | 60.0 | 1 | 60.0 | | |
| | **Дүн** | **4** | **6,426.8** | | | **4** | **6,426.8** | **4** | **6,426.8** | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| д/д | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс: Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| 1 | Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалын дагуу Санхүүгийн тайлангийн мэдээлэл агуулсан тодруулга тайлан бэлтгээгүй байна. | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| 2 | Байгууллагын үндсэн үйл ажиллагаанд ашиглагдаж буй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 233 ширхэг 46,934.2 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоогоогүй байна. | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| | **Дүн** | **2** | **-** | | | | | **2** | **-** | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

*/мянган төгрөг/*

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил** | | | | | | | | |
| Таван сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй орлого гүйлгээнээс 154,805.7 мянган төгрөгийн орлогын мэдээлэл, цалингаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй зарлага гүйлгээнээс 51,614.6 мянган төгрөгийн зарлагын мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн байна | 1 | 206,420.3 | | | | | 1 | 206,420.3 |
| **Нийт дүн** | **1** | **206,420.3** | | | | | **1** | **206,420.3** |

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn